



САНГИЙН ЯАМ

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ний өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Сангийн сайдын дангаар болон бусад сайдтай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний 2022 оны байдлаарх хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгсөн тайланг танилцуулж байна.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасны дагуу "Алсын хараа-2050"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2022 оны байдлаарх хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд "Алсын хараа-2050"-д нийт 26 арга хэмжээнээс Сангийн сайдын хариуцан хэрэгжүүлэх үүрэгт хамааралгүй 7 арга хэмжээг хасаж тооцвол 19 арга хэмжээнээс 12 арга хэмжээ 100.0 хувийн, 4 арга хэмжээ 90.0 хувийн, 3 арга хэмжээ 70.0 хувийн хэрэгжилттэй, ерөнхий дүнгээр 95 хувьтай байна.

Алсын хараа - 2050
2022 оны жилийн эцэс

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
Гурав. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА							
1	3.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.	3.3.19. Зээлийн батлан даалтын санг сурталчлах, үйл ажиллагааг нь өргөжүүлж сайжруулна.	2020 - 2050			Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар тус хуульд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг баталж, уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр төрөөс хэрэгжүүлж буй төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогын хүрээнд урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн тус сангаар дамжуулан зээлийн батлан даалтын үйлчилгээ авах эрх зүйн боломж бүрдсэн. Тухайлбал, орон сууцны урьдчилгаа төлбөрийн дутагдалтай иргэн тус санд хандаж зээлийн батлан даалтын үйлчилгээ авснаар банкнаас тогтоосон 30 хувийн урьдчилгаа төлбөрийн 60 хүртэлх хувийг буюу нийт урьдчилгаа төлбөрийн 18 хүртэлх хувьд тус сангаар батлан даалт гаргуулж, үлдсэн 12 хувийг өөрөө бүрдүүлэх замаар орон сууцны зээлд хамрагдах боломж бүрдсэн. Түүнчлэн коронавируст /Ковид-19/ цар тахлын сөрөг нөлөөг бууруулах зорилгоор батлагдсан Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн төлөвлөгөө батлах тухай 42 дугаар тогтоолоор Зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, тус сангаас нэмж 1 их наяд төгрөгийн зээлийн	100%

					батлан даалт гаргах санхүүгийн чадавхыг бүрдүүлсэн. Ингэснээр дээрх тогтоолын хүрээнд арилжааны банкнуудаар дамжуулан олгосон Ажлын байрыг дэмжих зээл, Репо санхүүжилтийн зээлд хамрагдах санхүүгийн хэрэгцээ шаардлагатай боловч барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн, аж ахуйн нэгжүүдэд тус сангаас үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн.	
2		3.3.23. Экспорт, импортын зах зээлтэй холбоотой мэдээллийг цахимжуулж, экспортын зах зээлд нэвтрэх боломжийг бүрдүүлж, бодлогоор дэмжинэ.	2020 - 2050		Гаалийн үйлчилгээний цахим портал болох https://gaali.mn/ , https://www.customs.gov.mn/ болон www.e-mongolia.com хаягаар дамжуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухай бүр Гаалийн байгууллагаас үзүүлэх төрийн үйлчилгээг үзүүлж байна. Иргэн, аж ахуйн нэгжийн экспортын зах зээлд нэвтрэх боломжийг бүрдүүлэх зорилгоор https://www.customs.gov.mn/ - ны загвар, бүтцийг өөрчилж, - Гаалийн цахим лавлагаа - Гаальд барааг цахимаар мэдүүлэх - Тусгай зөвшөөрөл - Хилийн хорио цээрийн гэрчилгээ мэдэгдэл - Гаалийн статистик мэдээ - Санал хүсэлт гэсэн үндсэн цэс бий болгон, холбогдох мэдээ, мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна. www.facebook.com дахь Гаалийн байгууллагын профайл хуудсаар дамжуулан тухай бүр холбогдох мэдээ, мэдээллийг хүргэн ажиллаж байна. Тайлант хугацаанд тус хуудсанд 180 мэдээ нийтлэгдсэн, нийт 230 ширхэг зурагт хуудас болон бусад контентын эхийг бэлтгэн, оруулсан байна.	100%
Дөрөв. ЭДИЙН ЗАСАГ						
3	4.1. Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн	4.1.1. Гадаадын зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд зардал, үр ашгийн тооцоолол хийж, зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх	2020 - 2050		Гадаад зээлээр хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний мэдээллийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 42 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах аргачлал"-ын дагуу боловсруулж, төсөвт өртгийг тооцох, үнэлэх, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор эрэмбэлдэг бөгөөд Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах,	100%

	зонхилох бүлэг болгоно.	тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлнэ.			эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмыг баримтлан төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байна.Түүнчлэн, Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн 1 дүгээр зорилтод "Эдийн засгийн бодит өсөлт болон экспортын орлогыг нэмэгдүүлэхгүй, гадаад улс орны худалдан авалтыг дэмжих замаар импортыг өсгөж, төлбөрийн тэнцэлд дарамт учруулах нөлөө бүхий Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрийг авч ашиглахаас татгалзах;" болон "Өрийн удирдлагын тухай хуулийн 7.1.6-д[10] зааснаас бусад тохиолдолд зөвхөн бодит эдийн засгийн салбарт чиглэсэн төслийг санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын гадаад зээл авч ашиглах;" гэж тусгасан бөгөөд энэхүү зорилтыг хэрэгжүүлж ажиллаж байна.	
4		4.1.2. "Ирээдүйн өв сан"-д орлого төвлөрүүлэх, баялгийн сангийн хөрөнгийг оновчтой удирдан, эрсдэл даах эдийн засгийг бүрдүүлнэ.	2020 - 2050		Ирээдүйн өв сангийн тухай болон Төсвийн тухай хуулийн дагуу жил бүр Ирээдүйн өв санд төвлөрүүлэх орлогыг тухайн жилийн төсвийн тухай хуулиар баталж байгаа ба 2021 оны жилийн эцсийн байдлаар тус санд 2.5 их наяд төгрөгийг хуримтлуулаад байна. Тайлант хугацаа буюу 2022 онд Ирээдүйн өв санд төвлөрсөн эх үүсвэрээс Монгол Улсын 0-18 хүртэлх насны иргэн бүрд мөнгөн хуримтлал үүсгэх зориулалтаар зарцуулалт хийж байгаа тул тус санд 2022 онд хуримтлал нэмж үүсэхгүй болно.	100%
5		4.1.3. Болзошгүй ер төлбөрийн төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог хөгжүүлнэ.	2020 - 2050		Засгийн газрын болзошгүй ер төлбөрийн төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог хөгжүүлэх зорилтын хүрээнд Засгийн газрын 2021 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан "Засгийн газрын өрийн баталгааны дагуу байгуулах гэрээ, түүнд тавигдах шаардлага, авлага барагдуулах журам"-ыг баталсан бөгөөд энэхүү журмын 10 дугаар зүйлийн 10.4.4 дэх заалтад "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр эрсдэлийн үнэлгээг шинэчлэн хийх бөгөөд эрсдэлийн үнэлгээний үзүүлэлт буурсан, нөхцөл байдал өөрчлөгдсөн тохиолдолд дүгнэлтийг Засгийн газарт танилцуулах;" гэж	100%

					тусгасан. Түүнчлэн Улсын Их Хурлын 2022 оны 26 дугаар тогтоолоор "Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг"-ийн 5 дугаар зорилтод "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гаргах Засгийн газрын өрийн баталгаанаас төсөвт үүсэж болзошгүй эрсдэлийг үнэлэх, эрсдэлээс сэргийлэх чиглэлээр өрийн удирдлагын чадавхыг бэхжүүлж, бүртгэл хөтлөх, тайлагнах механизмыг бүрдүүлэх;Засгийн газрын өрийн баталгаа гаргасан төслүүдийн эргэн төлөлт, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах;" гэж тус тус тусгасан.	
6		4.1.4. Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг барагдуулж, хугацаанаас нь өмнө худалдан авах, дахин санхүүжүүлэх арга хэмжээг авна.	2020 - 2050		Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн 1 дүгээр зорилт, Засгийн газрын 2021 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын гадаад үнэт цаас гаргах, арилжаалах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх ачааллыг жигдлэх, өрийн үйлчилгээний зардлыг бууруулах зорилгоор 2022-2023 онд эргэн төлөгдөх “Гэрэгэ” бондын 16.3 сая ам.доллар, “Чингис” бондын 2.5 сая ам.доллар буюу нийт 18.8 сая ам долларын Засгийн газрын гадаад үнэт цаасыг зах зээл уналттай байгаа цааш үеийг ашиглан эргэн төлөгдөх үнээс хямд өртөгтэй-ээр нээлттэй зах зээл дээрээс буцаан худалдан худалдан авах өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Дээрх нээлттэй зах зээл дээрээс буцаан худалдан авах өрийн зохицуулалтын үр дүнд Засгийн газрын өрийн үйлчилгээний зардлаас нийт 1.4 сая ам.долларын үндсэн болон хүүгийн төлбөрийн хэмнэлтийг улсын төсөвт гаргасан. Түүнчлэн, зээлжих зэрэглэл тогтоогч агентлагууд болон Засгийн газрын гадаад үнэт цаасны хөрөнгө оруулагчдын итгэлийг хадгалах, харилцааг сайжруулах ажлын хүрээнд тэдэнд Монгол Улсын нийгэм эдийн засаг, төсөв санхүүгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагын талаарх мэдээллийг	100%

					тогтмол хүргэн ажиллаж, биет болон цахим уулзалтуудыг тухай бүр зохион байгуулан ажиллаж байна.	
7	4.1.6. Улсын төсвийн сахилга бат, санхүү, мөнгө, зээлийн бодлого, зохицуулалтын удирдлагыг сайжруулна.	2020 - 2050			Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь нь 2020 онд 12.5 хувь, 2021 онд 8.8 хувь, 2022 онд 5.1 хувьтай тэнцэхээр батлагдсан. Засгийн газрын 2023-2025 оны стратегийн баримт бичиг хэрэгжих хугацаанд энэхүү үзүүлэлт буурч 2025 оноос эхлэн төсвийн алдагдал ДНБ-ний 2 хувиас хэтрэхгүй, эсхүл ашигтай байх төлөвлөгөөтэй байна. Засгийн газрын гадаад үнэт цаасны хувьд 2020 онд хугацаа тулаад байсан “Мазаалай” бонд болон “Чингис” бондын төлбөрийг “Номад” бондоор төлсөн бөгөөд хуваарьт хугацаанд “Мазаалай” үнэт цаасны 133 сая ам.долларын төлбөрийг төсвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс төлж барагдуулсан. Түүнчлэн, 2021 онд “Чингис” бонд болон “Гэрэгэ” бондын үндсэн төлбөрийг “Сенчири” бондоор өрийн зохицуулалтын арга хэмжээ авсан бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр үлдэгдэл төлбөр болох 137 сая ам.долларыг төлж барагдуулахаар төлөвлөж байна.	90%
8	4.1.7. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг үе шаттай бууруулж, улмаар ашигтай болгож, хуримтлал үүсгэж, төсвийн тогтвортой байдлыг хангана.	2020 - 2050			2021 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ "Нэмэлт өөрчлөлтөөр 1 дүгээр зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:19.9.Энэ хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2017 онд 10.4 хувиас, 2018 онд 9.5 хувиас, 2019 онд 6.9 хувиас, 2020 онд 12.5 хувиас, 2021 онд 8.8 хувиас, 2022 онд 5.1 хувиас, 2023 онд 3.6 хувиас, 2024 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна." 2 дугаар зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн "2023" гэснийг "2025" гэж, 19.2 дахь	90%

					хэсгийн "2021" гэснийг "2024" гэж, 19.3 дахь хэсгийн "2021 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна." гэснийг "2021 болон 2022 оны төсвийн жилд 70 хувиас, 2023 оны төсвийн жилд 65 хувиас, 2024 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна." гэж тус тус заасан.	
9	4.1.8. Хөгжлийг дэмжих бодлого, төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах судалгааны институт байгуулж ажиллуулна.	2020 - 2050			Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн дугаар 55 тогтоолоор Шинэ сэргэлтийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, оролцогч байгууллага, салбарын үйл ажиллагааны уялдааг хангах, мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий "Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв" улсын төсөвт үйлдвэрийн газрыг байгуулж, тус төвийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, гүйцэтгэх захирал, үйл ажиллагаа явуулах дүрмийг тус тус баталсан.	100%
10	4.1.9. Эдийн засгийн мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.	2020 - 2050			Монгол улсын 2023 оны төсвийн бодлогыг боловсруулахдаа үнийн өсөлтийн дарамтаас үүдэн эдийн засгийн сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг дэмжих, төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, нөөцийг оновчтой хуваарилах замаар хүүхдийн мөнгийг хэрэгцээт бүлэгт чиглүүлэх, уул уурхайн компанийн хандив тусламжийг орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр болгох, мөнгөний бодлогыг чангаруулан, төсвийн зардлыг хязгаарлаж, гадаад өрийн дарамтыг бууруулахын зэрэгцээ зээлжих зэрэглэлийг хадгалах зэрэг замаар эдийн засгийг тогтворжуулах бодлогыг баримталсан.	100%
11	4.1.10. Татварын шинэ хуулийг хэрэгжүүлж, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлнэ.	2020 - 2050			Далд эдийн засгийг бууруулах, татварын тайлагнал, бүртгэлийг нэмэгдүүлэх, Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т заасан татвар шударга байх үндсэн зарчмыг хэрэгжүүлэх, төрийн бүтээмжийг дээшлүүлэх, бизнес орчныг дэмжих зорилгоор Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж 2022 оны төсвийн тухай хуулийн төслийг дагалдуулан УИХ-аар хэлэлцэн баталсан.	100%

12	4.1.11. Тансаг зэрэглэлийн бараа, бүтээгдэхүүний импортын татвар, зохицуулалтыг олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан хүрээнд үр ашигтай хэрэгжүүлнэ.	2020 - 2050		Дэлхийн улс орнуудын туршлагаас тансаг зэрэглэлийн үл хөдлөх хөрөнгө, автомашин болон хэрэглээний бараа бүтээгдэхүүнд тусгайлан тансаг хэрэглээний татвар ногдуулах, тус татварыг нийгмийн дээд давхаргад ногдуулж төсвийн зарлага хэлбэрээр нийгмийн доод давхаргад зарцуулах, нийгмийн тэгш бус байдлыг бууруулах асуудлыг судалж байна.	70%
13	4.1.12. Инфляцыг зорилтот түвшинд хадгалж, эрсдэл даахуйц гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхийг дэмжсэн мөнгөний бодлого хэрэгжүүлнэ.	2020 - 2050		Монголбанк /Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5 болон 11 дүгээр зүйл./ Сангийн яамны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнээс хасах шаардлагатай.	100%
14	4.1.13. Төв банкны гадаад өрийг бууруулах зорилгоор Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ардын банкттай байгуулсан “СВОП” хэлцлийн хүрээнд үүссэн өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэнэ.	2020 - 2050		Монголбанк /Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5 болон 11 дүгээр зүйл./ Сангийн яамны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнээс хасах шаардлагатай.	100%

15	4.1.14. Макро эдийн засгийн зорилттой нийцүүлж, төсөв, мөнгөний бодлогыг харилцан уялдаатайгаар хэрэгжүүлнэ.	2020 - 2050			Нэрлэсэн ДНБ 2021 онд 43.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 14.9 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 27 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.4 хувиар тус тус өслөө. Эдийн засгийн өсөлтийг салбараар авч үзвэл хөдөө аж ахуйн салбар 5.5 хувиар, барилгын салбар 32.7 хувиар, тээврийн салбар 16.7 хувиар тус тус агшсан нь бодит өсөлт буурахад голлон нөлөөлсөн бол уул уурхайн салбарын өсөлт болон дотоодын эдийн засгийн сэргэлт нь эдийн засгийн агшилтыг хязгаарлахад гол хувь нэмэр оруулсан байна.	70%
16	4.1.15. Санхүүгийн системийн эмзэг байдлыг бууруулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.	2020 - 2050			Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпорациас хамтран санхүүгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, санхүүгийн зах зээлийн зохицуулалт, хяналтын бүтцийг сайжруулах, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх зорилгоор "Санхүүгийн салбарын дунд хугацааны бодлогын арга хэмжээний төлөвлөгөө /2022-2024/"-ний төслийг хамтран боловсруулж байна.	70%
17	4.1.16. Дамжин өнгөрүүлэх тээвэр, худалдаа, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг тээвэр, логистик, хилийн дэд бүтцийн хамт байгуулан эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангана.	2020 - 2050			Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүрэгт хамаарах асуудал тул Сангийн яамны хариуцах арга хэмжээнээс хасах шаардлагатай.	100%
18	4.1.20. Экспортын тэргүүлэх ач холбогдол бүхий салбаруудын	2020 - 2050			Экспортын тэргүүлэх ач холбогдол бүхий уул уурхайн салбарын бүтээгдэхүүнүүд болох нүүрс, зэсийн зах зээлийн талаар холбогдох мэдээлэл, тоон өгөгдөлд харьцуулсан дүн шинжилгээ хийж, тухайн түүхий эдийн дэлхийн зах зээлийн	100%

		бараа бүтээгдэхүүний судалгаа, маркетингийг дэмжинэ.			түүхэн нөхцөл байдал, үнийн төсөөлөл, болон Монгол Улсын зах зээлийн талаар суурь судалгааг тогтмол хийж гүйцэтгэн Даваа гараг бүрийн Сангийн сайдын шуурхай хуралдаанд танилцуулж байна. 2022 оны 11 дүгээр сарын 22-ны байдлаар нийт экспортын дүн 10618 сая ам.долларт хүрсэн. Экспортын гаалийн хяналтын төлөвийн 21% нь улаан төлөвт, 40% нь улбар шар төлөвт, 39% нь ногоон төлөвт сонгогдсон бөгөөд бараанд хийх шалгалтаас 79% нь чөлөөлөгдсөн нь өмнөх оны мөн үеэс 5%-аар өссөн үзүүлэлтэй байна.	
19		4.1.21. Төсөв, мөнгө, зээл, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын харилцан уялдаатай бодлого хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлт болон бүтцийн өөрчлөлтийн ололтыг цаашид тогтвортой хадгална.	2020 - 2050		Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2021 онд 16.1 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 25.1 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 2.4 тэрбум ам.долларын ашигтай гарч өмнөх оноос 5.1 хувиар өссөн байна. экспортоор 9.2 тэрбум ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь 2020 оноос 22.1 хувиар өссөн үзүүлэлт болж байна. Уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний үнэ өссөнтэй холбоотойгоор экспортын орлого нэмэгдсэн байна. Импортоор 6.8 тэрбум ам.долларын бараа, түүхий эд худалдан авсан нь өмнөх оноос 29.4 хувиар өсжээ. Импортын өсөлтөд тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги, химийн бүтээгдэхүүн, машин механизм, тоног төхөөрөмж, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүний импорт голлон нөлөөлсөн байна.	90%
20		4.1.24. Макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хадгалж, ажилгүйдлийг нам түвшинд тогтвортой хадгална.	2020 - 2050		Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүрэгт хамаарах асуудал тул Сангийн яамны хариуцах арга хэмжээнээс хасах шаардлагатай.	100%
21	4.4. Бүс нутгийн эдийн засаг, худалдааны	4.4.2. Бараа, үйлчилгээг худалдах,	2020 - 2050		Гаалийн үйлчилгээний цахим портал болох https://gaali.mn/ , https://www.customs.gov.mn/ болон www.e-mongolia.com хаягаар дамжуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухай	100%

	интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө.	тээвэрлэх, хянах, хөрөнгө оруулах, зах зээлд нэвтрэх нөхцөлүүдийг ил тод болгох, бүртгэл ба мэдээллийн нэгдсэн системийг бий болгох, цаасгүй технологи нэвтрүүлэх, эрсдэлд суурилсан удирдлага ба хяналтыг бий болгоно.			бүр Гаалийн байгууллагаас үзүүлэх төрийн үйлчилгээг үзүүлж байна. Иргэн, аж ахуйн нэгжийн экспортын зах зээлд нэвтрэх боломжийг бүрдүүлэх зорилгоор https://www.customs.gov.mn/ - ны загвар, бүтцийг өөрчилж, - Гаалийн цахим лавлагаа, - Гаальд барааг цахимаар мэдүүлэх, - Тусгай зөвшөөрөл - Хилийн хорио цээрийн гэрчилгээ мэдүүлэг - Гаалийн статистик мэдээ - Санал хүсэлт гэсэн үндсэн цэс бий болгон, холбогдох мэдээ, мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна www.facebook.com дахь Гаалийн байгууллагын профайл хуудсаар дамжуулан тухай бүр холбогдох мэдээ, мэдээллийг хүргэн ажиллаж байна. Тайлант хугацаанд тус хуудсанд 180 мэдээ нийтлэгдсэн, нийт 230 ширхэг зурагт хуудас болон бусад контентын эхийг бэлтгэн, оруулсан байна.	
22		4.4.10. Цөөхөн улс орон, цөөн зах зээлээс хараат байдлаасаа ангижрахын тулд тээврийн өртөг зардлаа бууруулах, нэмэгдсэн өртөг бүтээх, үүний тулд аж үйлдвэржилтийн томоохон төслүүдэд хөрөнгө оруулах чадвартай, харилцан ашигтайгаар хамтран ажиллана.	2020 - 2050		Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүрэгт хамаарах асуудал тул Сангийн яамны хариуцах арга хэмжээнээс хасах шаардлагатай.	100%
Тав. ЗАСАГЛАЛ						

23	5.1. Эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана.	5.1.7. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсвийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулах тогтолцоонд шилжинэ.	2020 - 2050		Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2023 оны төсвийн бодлогод "Шинэ сэргэлтийн бодлого"-г дэмжих замаар эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэхээр тусгаж батлуулсан. Тус бодлогыг хэрэгжүүлсний үр дүнд Эдийн засгийн өсөлт нэмэгдэж, нэг хүнд ногдох орлого өсөж, ажиллах хүчний оролцооны түвшин дээшилж, боомтын хүчин чадал нэмэгдэнэ.	90%
24	5.2. Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна.	5.2.12. Төв банкны мөнгөний бодлого нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн байх улс төр, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	2020 - 2050		Монголбанк /Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5 болон 11 дүгээр зүйл./ Сангийн яамны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнээс хасах шаардлагатай.	100%
25	5.2.22. Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжихэд чиглүүлэн, олон нийтэд нээлттэй, хяналттай	5.2.22. Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжихэд чиглүүлэн, олон нийтэд нээлттэй, хяналттай	2020 - 2050		Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжихэд чиглүүлэх, олон нийтэд нээлттэй, хяналттай тогтолцоонд шилжүүлэх чиглэлээр анхаарч, Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан ангиллын дагуу жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нарт зээл олгох үйл ажиллагааг зохион байгуулж байгаа болно. Үүнд: ·Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчинд 10.0 сая хүртэл төгрөг, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэнд 25.0 сая хүртэл төгрөг, бичил үйлдвэрлэл,	100%

		тогтолцоонд шилжүүлнэ.			үйлчилгээ эрхлэгчид 50.0 сая хүртэл төгрөгийн жижиг зээлийг олгох; ·Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 300.0 сая хүртэл төгрөг, жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 1.0 тэрбум хүртэл төгрөг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 2.5 тэрбум хүртэл төгрөгийн зээлийг олгохоор зохицуулсан болно.Тусгай сангуудын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэлээр Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд “тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлэх”, “тусгай сангаас зээл, буцалтгүй тусламж, санхүүгийн дэмжлэг авахаар хүсэлт ирүүлсэн иргэд, хуулийн этгээдийн бизнес төлөвлөгөөгөө танилцуулах, түүнийг сонгон шалгаруулах, үнэлэх үйл явцыг олон нийтийн хэвлэл мэдээллээр нээлттэй, ил тод зохион байгуулах”, “тусгай сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах хороо, төслийн удирдах хороо болон хяналтын хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулах ба тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавихад олон нийтийн оролцоог хангах” заалтуудыг тусгасан.	
Найм. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ						
26	8.1. Бүс нутгийн эдийн засгийн интеграцад дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, эдийн засгийн	8.1.8. Хавирга, Гашуунсухайт, Шивээ хүрэн, Булган, Боршоо, Арц суурь, Бага Илэнхи зэрэг хилийн боомтуудын	2020 - 2050		Хилийн боомтын үндэсний зөвлөлийн чиг үүрэгт хамаарах асуудал тул Сангийн яамны хариуцах арга хэмжээнээс хасах шаардлагатай.	100%

эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.	нэвтрэх чадварыг нэмэгдүүлнэ.					
--	----------------------------------	--	--	--	--	--

“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Мэдээллийн эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах арга зүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хэрэгжилт	Үнэлгээ
				2025	2030	2050					
ЗУРГАА.НОГООН ХӨГЖИЛ											
61	Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувь	хувь	-	10	20	50	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Худалдан авах ажиллагааны газар	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцэн хуулийн төсөл болон дагалдах хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон. Тус хуулийн төсөлд бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолтыг байгаль орчин, хүрээлэн буй орчинд ээлтэй байдлаар боловсруулах талаар тодорхой зохицуулалтыг тусгаснаас гадна тендерийг үнэлэхэд "ашиглалтын хугацааны өртөг"-т үндэслэн ашиглалтын зардал багатай, сэргээгдэх эрчим хүч ашигладаг бараа, бүтээгдэхүүн, барилга байгууламжийг өндөр үнэтэй ч худалдан авах боломжийг олгохоор тусгасан.	100%